

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ДУНДГОВЬ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР



ДУАГ

ДУНДГОВЬ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

Монгол Улсын Их Хурлын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн зардлын гүйцэтгэлд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан / УАГ-ГАГ/2016/07-ГА/



2016 он

Улсын Их Хурал,
аймгийн иргэдийн
Төлөөлөгчдийн
Хурлын сонгууль
зохион байгуулах
зардлыг Сонгуулийн
Ерөнхий Хорооноос
өгсөн чиглэлийн
дагуу зарцуулжээ.

АГУУЛГА

<u>Тайланг бэлтгэсэн:</u>	Товчилсон үгс	3
Дундговь аймгийн Аудитын газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй Ерөнхий мэдээлэл	4 5
Тэргүүлэх аудитор Т.ОЮУНЧИМЭГ	Бүлэг 1. Аймгийн ИТХ-ын сонгуулийг зохион байгуулах хөрөнгийг холбогдох хууль, журмын дагуу зарцуулсан байна.	6
Аудитын менежер Б.ГАНТУЯА	1.1 Зарим сумдын сонгуулийн хороонд хуваарилсан төсөв сумдын эдийн засаг, статистикийн тоон үзүүлэлттэй уялдахгүй байна.	6-11
Ахлах аудитор Х.Наранцацрал	1.2 Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан боловч нийт гүйцэтгэлийн 0.3 хувьд зөрчил илэрлээ.	12-13
Шинжээч Ч.Бэрхсайхан	Бүлэг 2 Сонгууль зохион байгуулах зардлын гүйцэтгэлийг бодитой тайлагнасан боловч зарцуулалтад хяналт тавиагүй байна.	14
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 99945663, 93132017 дугаарын утсаар харилцана уу.	2.1 Аймгийн сонгуулийн хорооны сонгууль зохион байгуулах зардлын гүйцэтгэл 95 хувьтай байна.	14-15
	2.2 Аймгийн сонгуулийн хорооноос сонгуулийн зардлын зарцуулалтад хяналт тавиагүй байна.	16
ХАЯГ: Сайнцагаан сум 7-р баг, Нутгийн удирдлагын ордон, 209 тоот	Дээд шатны байгууллагад хүргүүлэх санал	17
	Дүгнэлт	18
	Шалгагдагч байгууллагаас ирүүлсэн санал тайлбар	19
	Аудитын газрын тайлбар	20
2016 оны 8 дугаар сар	Тайлан баталгаажуулсан тушаал	21-23
	Тайлангийн хавсралтууд	24-28

ТОВЧИЛСОН ҮГС

МУ	Монгол Улс
УИХ	Улсын Их Хурал
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ҮАГ	Үндэсний Аудитын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
СЕХ	Сонгуулийн Ерөнхий Хороо
АСХ	Аймгийн сонгуулийн хороо
МТБ	Мэдээллийн технологийн баг
ЗБ	Зохион байгуулагч

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх: Аудитыг Үндэсний аудитын газрын харьяа Дундговь аймгийн Аудитын газрын 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон орон нутгийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт: Улсын Их Хурлын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны ээлжит сонгуулийг зохион байгуулахтай холбоотой төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалт, үр дүнг шалгаж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, аймгийн сонгуулийн хороонд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- ❖ УИХ-ын болон аймаг, нийслэлийн ИТХ-ын сонгуулийг зохион байгуулах хөрөнгийг холбогдох хууль, журмын дагуу зарцуулсан эсэх.
- ❖ Хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт үр дүнтэй эсэх.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт: Дараах хууль эрхийн актыг аудитын шалгуур, эх сурвалж болгон ашиглав.

- Төрийн аудитын тухай хууль,
- Төсвийн тухай хууль,
- Сонгуулийн тухай хууль,
- Сонгуулийн төв байгууллагын тухай,
- Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль,
- Дээрх хуулиудад нийцүүлэн гаргасан тогтоол, журам.

Аудитын хамрах хүрээ: Аудитад аймаг, сумдын сонгуулийн хороод болон аймгийн Улсын бүртгэл, статистикийн газар, аймгийн Цагдаагийн газарт сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлийг хамруулав.

Аудитын арга зүй: Аудитын олон улсын стандарт, АДБОУС, Гүйцэтгэлийн аудитын удирдамж, Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, гүйцэтгэлийн аудитын арга зүйг мөрдөж, батлагдсан төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, тулган баталгаажуулах, зэрэгцүүлэх, харьцуулах зэрэг аудитын горимыг хэрэгжүүлэн, нотлох зүйл цуглуулж, аудитын дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитын хугацаа, багийн бүрэлдэхүүн: Аудитыг тэргүүлэх аудитор Т.Оюунчимэг хянан удирдаж, аудитын гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлын чанарын хяналтыг аудитын менежер Б.Гантуяа хийж, гүйцэтгэлийн аудитын багийн ахлах аудитор Х.Наранцацрал, шинжээч Ч.Бэрхсайхан нар 2016 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөс 09 дүгээр сарын 01-ний өдрийг дуустал гүйцэтгэлээ.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Сонгуулийн хороо

Дундговь аймаг УИХ-ын 2016 оны ээлжит сонгуульд 1 тойрог, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд 23 тойрогтой, аймгийн сонгуулийн хороо болон 15 сумын сонгуулийн хорооны нийт 52 хэсгийн хороо, 480 ажилтантайгаар зохион байгуулагдсан байна. /Сонгуулийн хороодод ажилласан ажилчдын судалгааг Хавсралт №1-д харуулав./

УИХ-ын 2016 оны 04 дүгээр сарын 07-ны 32 дугаар тогтоолоор баталсан сонгууль зохион байгуулахтай холбоотой зардалд улсын төсвөөс олгох санхүүжилтээс Сонгуулийн Ерөнхий Хороо Дундговь аймгийн сонгуулийн хороонд 258,619.2 мянган төгрөгийг хуваарилсан байна.

Хуваарилсан нийт төсвийн 49,025.4 мянган төгрөг буюу 18.9 хувийг аймгийн, 207,173.8 мянган төгрөг буюу 80.1 хувийг сумдын сонгуулийн хороонд тус тус хуваарилжээ. Харин 2,420.0¹ мянган төгрөг илүү тооцогдож ирсэн нь нийт төсвийн 1 хувь бөгөөд сумдад төсөв хуваарилахдаа дээрх дүнг хасч хуваарилсан байна.

Нийт 12,020.9 мянган төгрөгийн үлдэгдлийг Сонгуулийн Ерөнхий Хороонд төвлөрүүлжээ.

Улсын бүртгэл, статистикийн газар болон Цагдаагийн газар

Улсын Их Хурал, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбоотойгоор Улсын бүртгэл, статистикийн газрын төсөвт 30,832.8 мянган төгрөг, Цагдаагийн газрын төсөвт 5,839.0 мянган төгрөгийг тусгаж, улсын төсвөөс санхүүжүүлсэн байна.

Гүйцэтгэлээр Улсын бүртгэл, статистикийн газар 26,877.7 мянган төгрөг, Цагдаагийн газар 5,839.0 мянган төгрөгийг тайлагнажээ.

¹ Сайнцагаан сумын санал авах байранд ажиллах 10 хүний урамшуулал 1,920.0 мянган төгрөг, хоолны зардал 500.0 мянган төгрөгөөр илүү ирсэн.

1.1 Зарим сумдын сонгуулийн хороонд хуваарилсан төсөв сумдын эдийн засаг, статистикийн тоон үзүүлэлттэй уялдахгүй байна.

Сонгуулийн хороо

Дундговь аймгийн сонгуулийн хороонд хуваарилсан 258,619.2 мянган төгрөгийн санхүүжилтийг 3 хуваан олгосон бөгөөд эхний санхүүжилтийг 56,087.0 мянган төгрөгөөр, 2 дахь санхүүжилтийг 58,800.0 мянган төгрөгөөр, 3 дахь санхүүжилтийг 143,732.2 мянган төгрөгөөр олгож, төсөв зарцуулах зөвлөмжийг Сонгуулийн Ерөнхий Хорооны 2016 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 142 дугаар албан бичиг, 2016 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн 330 дугаар албан бичиг, 2016 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 392 дугаар албан бичгээр тус тус ирүүлсэн байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төсвийн төсөлд аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль зохион байгуулах зардлыг нэгтгэн тусгаж, батлуулсан боловч аймаг, сумаар салгаж тооцоогүй, Сонгуулийн Ерөнхий Хорооноос төсвийг хуваарилсан тул хөрөнгийн хэрэгцээ шаардлагыг бодитой тооцсон эсэхийг тодорхойлох боломжгүй байлаа.

Харин аймгийн сонгуулийн хороонд хуваарилсан зардлуудын төлөвлөгөө, гүйцэтгэлийг харьцуулахад саналын хуудас устгах зардлын гүйцэтгэл 5 хувь, сумдад саналын хуудас хүргэх томилолт унааны зардлын гүйцэтгэл 27 хувьтай байгаа нь тус 2 зардлын хувьд хуваарилалтыг бодитой бус хийсэн нь харагдаж байна. /Хүснэгт № 1.1-ийн 2, 12 дугаар мөр/

Хүснэгт 1.1 /мянган төгрөгөөр/

№	Зардлын нэр	Төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл	Гүйцэтгэлийн хувь
1	Гэрчилгээ олгох сургалтын зардал	3,100.0	3,078.0	22.0	99%
2	Саналын хуудас устгах	1,000.0	45.5	954.5	5%
3	Тогтоол, протокол, маягт, материал хэвлүүлэх	1,650.0	1,560.1	89.9	95%
4	Бичиг хэргийн зардал	800.0	625.7	174.3	78%
5	Шуудан холбоо	2,600.0	1,643.7	956.3	63%
6	Унааны зардал	3,000.0	2,964.5	35.5	99%
7	Сургалтын зардал	6,673.0	5,366.4	1,306.6	80%
8	Хууль сурталчлах зардал	4,020.0	3,970.3	49.7	99%

9	МТБ, даамалын сургалт		5,514.0	5,439.0	75.1	99%
10	Санал авах байр бэлтгэх, тохижуулах зардал		1,290.0	1,290.0	0.0	100%
11	Саналын хуудас	УБ хотоос саналын хуудас авах томилолт унаа	488.0	488.0	-	100%
12		Сумдад саналын хуудас хүргэх томилолт унаа	4,812.0	1,309.3	3,502.7	27%
13	ICP машин хүлээн авах хүлээлгэн өгөх	МТБ техник хэрэгслийг СЕХ-оос хүлээн авах томилолт, унаа	763.0	743.2	19.8	97%
14		МТБ техник хэрэгслийг СЕХ-нд хүлээлгэн өгөх томилолт ,унаа	763.0	763.0	-	100%
15		МТБ техник хэрэгслийг сумдад хүлээлгэн өгөх томилолт ,унаа	3,437.0	2,456.5	980.5	71%
16	Урамшуулал хоол/ня-бо, бичиг хэрэг/		1,700.0	1,700.0	-	100%
17	МТБ-н мэдээ дамжуулах зардал		600.0	600.0	-	100%
18	Томилголт	Саналын хуудас баталгаажуулах	488.0	488.0	-	100%
19		Сонгуулийн дүнг СЕХ-д хүлээлгэн өгөх	488.0	488.0	-	100%
20		АСХ-ны ня-бо СЕХ-д дүн мэдээ хүргэх	351.0	351.0	-	100%
21	Мөнгөн урамшуулал хоол	АСХ-ны гишүүдийн урамшуулал	3,110.4	3,110.4	-	100%
22		Сонгуулийн байгууллагын ажилтнуудын хоолны зардал	450.0	450.0	-	100%
23	Мөнгөн урамшуулал хоол	МТБ-н урамшуулал	1,728.0	1,728.0	-	100%
24		МТБ-н хоол	200.0	200.0	-	100%
Дүн			49,025.4	40,858.5	8,166.9	

Сонгууль зохион байгуулах зардлыг сумдын сонгуулийн хороонд хуваарилахдаа Сонгуулийн Ерөнхий Хорооноос ирүүлсэн зөвлөмжүүдийг үндэслэсэн байна.

Аймгийн сонгуулийн хорооноос сумдад хуваарилсан төсвийг сумдын өрхийн тоо, сонгуулийн насны хүн ам, газар нутгийн хэмжээнд үндэслэн тооцож үзэхэд харьцангуй зөрүүтэй байна. Тухайлбал: Өлзийт, Дэлгэрхангай, Өндөршил сумд нь бусад сумдтай харьцуулахад газар нутгийн хэмжээ, хүн амын тоогоор их боловч тус сумдад харьцангуй бага төсөв хуваарилсан. /Хүснэгт № 1.2-ын 2, 4, 7 дугаар мөр/

Гэтэл Гурвансайхан, Дэрэн, Луус, Адаацаг сумд нь аймгийн төвтэй ойр, бусад сумдтай харьцуулахад газар нутгийн хэмжээ, хүн амын тоогоор бага бөгөөд тус сумдад харьцангуй их төсөв хуваарилсан. Энэ нь сонгуулийн хэсгийн хороог баг тус бүрт байгуулсантай холбоотой байна. /Хүснэгт № 1.2-ын 8, 9, 12, 13 дугаар мөр/

Хүснэгт № 1.2

№	Сонгуулийн хорооны нэр	Дундаж ² эзлэх хувийн жин	Олгосон төсвийн нийт төсөвт эзлэх хувийн жин	Дундаж ³ эзлэх хувийн жингээр эрэмбэлсэн үзүүлэлт	Олгосон ⁴ төсвийн эзлэх хувийн жингээр эрэмбэлсэн үзүүлэлт
1	Аймаг /Сайнцагаан/	14.77	31.30	1	1
2	Өлзийт	11.75	5.13	2	8
3	Эрдэнэдалай	10.31	8.94	3	2
4	Дэлгэрхангай	6.91	3.86	4	11
5	Сайхан-Овоо	6.76	5.33	5	7
6	Хулд	6.36	6.19	6	5
7	Өндөршил	6.26	2.76	7	12
8	Гурвансайхан	5.72	7.44	8	3
9	Адаацаг	5.53	6.43	9	4
10	Цагаандэлгэр	4.75	2.61	10	14
11	Баянжаргалан	4.74	4.41	11	10
12	Дэрэн	4.57	6.05	12	6
13	Говь-Угтаал	4.23	2.61	13	13
14	Луус	3.93	4.43	14	9
15	Дэлгэрцогт	3.40	2.52	15	15

Дээрх судалгаанаас харахад зарим сумдын сонгуулийн хороонд төсвийг хуваарилахдаа сумдын эдийн засаг, статистикийн тоон үзүүлэлтүүдийг харгалзахгүйгээр хуваарилсан байна.

Сонгуулийн тухай хуулийн 23.2-т /Нэг хэсэг нь суманд 2000-аас дээшгүй, аймгийн төвд 2500-аас дээшгүй, нийслэлийн дүүрэгт 3000-аас дээшгүй сонгогчтой байна./, мөн хуулийн 23.3-т /Баг, хороог бусад баг, хороотой нийлүүлж хэсэг байгуулахыг хориглох бөгөөд сонгогчдын тооноос хамааран баг, хороог хувааж хэсэг байгуулж болно./ гэж заасан.

Хуулийн 23.3-т зааснаар Дундговь аймаг 66 хэсгийн хороотой үйл ажиллагаа явуулахаар байгаа бөгөөд нэг хэсгийн хороонд хамгийн багадаа 78, хамгийн ихдээ 959 сонгогчтой байхаар байна. Харин 52 хэсгийн хороо байгуулснаар нэг хэсгийн хороонд хамгийн багадаа 262, хамгийн ихдээ 2109 сонгогч санал өгсөн бөгөөд сум болгон харилцан адилгүй байгаа юм. /Хүснэгт 1.3/

Хүснэгт 1.3

² Сумдын өрхийн тоо, сонгуулийн насны хүн ам, газар нутгийн хэмжээ, аймгийн төвөөс сумын төв хүртэлх зайг үзүүлэлт тус бүрийн нийт дүнтэй харьцуулан дундчилсан үзүүлэлт

³ Аудитаар тооцсон сонгуулийн хороодод хуваарилбал зохих төсвийг ихээхэн багаруу /1-их 15-бага/ жагсаасан үзүүлэлт

⁴ Аймгийн сонгуулийн хорооноос сумдын сонгуулийн хороодод хуваарилсан төсвийг ихээхэн багаруу /1-их 15-бага/ жагсаасан үзүүлэлт

Тойргийн нэр	1 хэсгийн хороонд санал өгөх сонгогчийн тоо	Сонгуулийн насны хүн ам	Хэсгийн хорооны тоо
Адаацаг	371	1854	5
Баянжаргалан	262	785	3
Говь-Угтаал	1,042	1042	1
Гурвансайхан	284	1418	5
Дэлгэрхангай	720	1439	2
Дэлгэрцогт	1,072	1072	1
Дэрэн	339	1357	4
Луус	401	1204	3
Сайнцагаан 1	445	445	1
Сайнцагаан 2	530	530	1
Сайнцагаан 3	618	618	1
Сайнцагаан 4	499	499	1
Сайнцагаан 5	1,171	1171	1
Сайнцагаан 6	1,255	1255	1
Сайнцагаан 7	2,109	2109	1
Сайнцагаан 8	1,376	1376	1
Сайнцагаан 9	1,633	1633	1
Сайхан-Овоо	475	1424	3
Хулд	386	1544	4
Цагаандэлгэр	665	665	1
Эрдэнэдалай	526	3682	7
Өлзийт	531	1593	3
Өндөршил	941	941	1

Тиймээс хүн ам багатай аймгийн хувьд дээрх заалтыг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй, сонгууль зохион байгуулах зардал өндөр гарах үр дагаврыг бий болгохоор байна. Иймд тус хуулийн заалтыг тохиромжтой байдлаар өөрчлөх саналтай байна.

Аудитын явцад сумдад хуваарилсан унааны зардлыг сумдын сонгуулийн насны хүн ам, газар нутгийн хэмжээ, аймгийн төвөөс сумын төв хүртэлх зайнд үндэслэн тооцоход дээрх судалгаатай ижил үр дүн гарч байгаа нь унааны зардлыг үндэслэлгүй хуваарилсан гэж үзэхээр байна. Энэ нь сонгууль зохион байгуулах зардал зарим сумдад хүрэлцэхгүй байх, үлдэгдэлтэй гарах нөхцөл байдлыг бий болгож байна.

Сонгуулийн тухай хуулийн 38.2-т УИХ, Ерөнхийлөгч, орон нутгийн хурлын сонгуулийн улсын төсвөөс санхүүжих 19 нэр төрлийн зардлын ангиллыг заасан. /Жич: 15 нэр төрлийн зардал нь орон нутгийн хурлын сонгуульд хамааралтай./

Үүнээс орон нутгийн хурлын сонгуультай холбоотой аймгуудын сонгуулийн хороонд хуваарилах 11 нэр төрлийн зардлыг Сонгуулийн Ерөнхий Хорооны 2016 оны 03 дугаар сарын 2-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор батлагдсан "Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам"-д тусгасан боловч СЕХ-оос төсөв хуваарилахдаа 19 нэр төрлийн зардал хуваарилжээ. Үүнээс:

1. Үнэмлэх хэвлэх зардал,
2. Сурталчилгааны зардал,
3. Саналын хуудас устгах зардал,
4. Болзошгүй зардал зэрэг нь журамд тусгагдаагүй боловч Сонгуулийн тухай хуульд нийцэж байна.

Сонгуулийн тухай хууль, Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам, Сонгуулийн Ерөнхий Хорооноос хуваарилсан зардлын зүйлийг харьцуулсан үзүүлэлтийг Хавсралт №2-т орууллаа.

Мөн тус журамд сумдын сонгуулийн хороонд хуваарилах 6 нэр төрлийн зардлыг заасан боловч Дундговь аймгийн хувьд СЕХ-оос ирүүлсэн зөвлөмжийн дагуу 19 нэр төрлийн зардлыг хуваарилж, гүйцэтгэлийг тайлагнажээ.

Дээрх байдлаас харахад Сонгуулийн Ерөнхий Хорооны 2016 оны 03 дугаар сарын 2-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор батлагдсан "Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам" нь Сонгуулийн тухай хуулийн холбогдох заалттай нийцээгүй, тодорхой бус байгаагаас хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байна. Тиймээс тус журмын 2.2, 2.3 дахь заалтууд мөрдөгдөхгүй байгаа талаар Сонгуулийн Ерөнхий Хороонд анхааруулах шаардлагатай.

Улсын бүртгэл, статистикийн газар

Улсын бүртгэл, статистикийн газрын төсөвт итгэмжлэгдсэн ажилтны мөнгөн урамшуулал 13,368.0 мянган төгрөг, сургалт зохион байгуулах зардал 14,751.8 мянган төгрөг, техник хэрэгсэл тээвэрлэж хүргүүлэх, татан авах зардал 2,713.0 мянган төгрөг, нийт 30,832.8 мянган төгрөгийг хуваарилсан. /Хүснэгт 1.4/

Хүснэгт 1.4 /мянган төгрөгөөр/

№	Зардлын зүйл /Сонгуулийн тухай хуулийн 38.3.1-38.3.7/	Төсөв	Гүйцэтгэл	Зөрүү
1	Техник хэрэгсэл тээвэрлэж хүргүүлэх, татан авах болон түүнтэй холбогдсон бусад зардал;	2,713.0	1,716.8	996.2
2	Мэдээлэл, сурталчилгаа явуулах, түүнтэй холбогдсон бусад зардал;			
3	Улсын бүртгэлийн байгууллагын ажилтан болон итгэмжлэгдсэн ажилтны зардал, мөнгөн урамшуулал, хоол, унааны зардал;	13,368.0	12,361.0	1,007.0

4	Сургалт зохион байгуулах, түүнтэй холбогдсон бусад зардал;	14,751.8	12,799.9	1,952.0
5	Мэдээлэл технологийн шуурхай багийн мөнгөн урамшуулал, хоол, унааны зардал;			
6	Нэмэлт болон дахин санал хураах, ээлжит бус болон дахин сонгууль явуулах тохиолдолд улсын бүртгэлийн байгууллагаас гаргах зардал;			
7	Онцгой нөхцөл байдал үүссэн үед гарч болзошгүй зардал.			
Дүн		30,832.8	26,877.7	3955.2

Улсын бүртгэл, статистикийн газрын сонгууль зохион байгуулахтай холбоотой зардлын гүйцэтгэл 26,877.7 мянган төгрөг бөгөөд 3,955.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Үүний 3,000.0 мянган төгрөгийг Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газраас 2016 оны 07 дугаар сарын 25-ны өдөр итгэмжлэгдсэн ажилтны мөнгөн урамшууллын зардалд хуваарилж, зарцуулах эрх нь нээгдсэн боловч зарцуулаагүй байна.

Сонгуулийн тухай хуулийн 38.3.5-д заасан мэдээлэл технологийн шуурхай багийн мөнгөн урамшуулалд төсөв хуваарилагдаагүйгээс ажилласан албан хаагчдад урамшуулал олгоогүй байна.

Цагдаагийн газар

Цагдаагийн газрын төсөвт хоолны зардал 4,305.0 мянган төгрөг, шуудан холбооны зардал 534.0 мянган төгрөг, шатахууны зардал 1,000.0 мянган төгрөг, нийт 5,839.0 мянган төгрөгийг хуваарилсан.

Сонгуулийн тухай хуулийн 38.4.1⁵, 38.4.2⁶-т заасан цагдаагийн байгууллагад олгох зардлын төрөлд шуудан холбооны зардал байхгүй боловч сонгуулийн хугацаанд хамгаалалтад гарсан албан хаагч нар нөхцөл байдлаа тухай бүр илтгэхэд тус зардал нь зарцуулагджээ.

⁵ 38.4.1.санал авах байрын хамгаалалт, шатахуун, техник хэрэгслийн зардал;

⁶ 38.4.2.цагдаагийн албан хаагчийн томилолт, мөнгөн урамшуулал, хоолны зардал.

1.2 Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан боловч нийт гүйцэтгэлийн 0.3 хувьд зөрчил илэрлээ.

Сонгууль зохион байгуулах зардлын гүйцэтгэлд аудит хийх явцад нийт 849.6 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан зөрчил илэрлээ. Тухайлбал:

- Өлзийт сумын сонгуулийн хороо сонгуулийн сургалтын зардлаас хоолны зардал, цайны материалын үнэ 549.0 мянган төгрөгийг сонгуулийн хорооны нарийн бичгийн дарга, гишүүдийн дансанд шилжүүлсэн.
- Аймгийн сонгуулийн хороо бичиг хэргийн зардлаас 9.0 мянган төгрөгийн цэвэр ус худалдаж авсан.
- Сайнцагаан сумын сонгуулийн хороо хууль сурталчлах зардлын гүйцэтгэлийг 3.0 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулж, сургалтын зардлаас зарцуулсан. Тус зөрчлүүдийг арилгах, дахин давтахгүй байх талаар аудитын явцад зөвлөв.
- Адаацаг сумын сонгуулийн хороо хууль сурталчлах зардлаас 64.8 мянган төгрөгийн хоолны мөнгө олгосон.
- Сайнцагаан сумын сонгуулийн хороо санал авах байр бэлтгэх, тохижуулах зардлаас 220.8 мянган төгрөгийн хүнсний зүйл худалдаж авсан зэрэг нийт 285.6 мянган төгрөгийн зөрчлийг нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоож, аудитын явцад төлбөрийг барагдууллаа.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 /Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;/, Сонгуулийн тухай хуулийн 32.1.6 /Улсын болон орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгийг зориулалтын дагуу захиран зарцуулах, хуваарилах, зарцуулалтад нь хяналт тавих;/, Сонгуулийн Ерөнхий Хорооны 2016 оны 03 дугаар сарын 2-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор батлагдсан "Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам"-ын 3.1 /Аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороо болон төв комисс, салбар комиссын дарга нь тухайн сонгуулийн хорооны зардлын дансны 1 дүгээр гарын үсгийг, томилогдсон нягтлан бодогч нь 2 дугаар гарын үсгийг зурж, энэ журмын 2.2, 2.3 дахь хэсэгт заасан хуваарилсан төсвийг зохих эдийн засгийн ангиллын дагуу захиран зарцуулна/ гэж заасныг тус тус зөрчсөн.

- Сонгуулийн Ерөнхий Хорооноос аймгийн сонгуулийн хороонд 3,000.0 мянган төгрөгийг онцгой нөхцөл байдал үүссэн үед гарч болзошгүй зардалд хуваарилсан. Тус зардлаас 2,676.0 мянган төгрөгийг галын хор болон бусад аж ахуйн шинжтэй хөрөнгө худалдан авах, цонхны хаалт хийх, мотор түрээслэх гэх мэт зардалд зарцуулжээ. Энэ нь Сонгуулийн тухай хуулийн 3.1.5-д /"онцгой нөхцөл байдал үүссэн" гэж сонгуулийг зохих ёсоор явуулахад

урьдчилан төлөвлөөгүй, төлөвлөх боломжгүй нэмэлт зардал, хөрөнгө зарцуулах зайлшгүй шаардлага бий болсныг;/ мөн Сонгуулийн Ерөнхий Хорооны 2016 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 392 дугаар албан бичгийн 1 дүгээр хавсралтын 3-т /Болзошгүй зардал: Байгалийн гэнэтийн аюул, цаг агаарын нөхцөл байдлаас гол ус үерлэх, зам хаагдах, холбоо тасрах тохиолдолд онцгой байдлын зориулалтаар хэрэглэнэ./ гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Сонгуулийн Ерөнхий Хорооны 2016 оны 03-р сарын 02-ны 05 дугаар тогтоолоор батлагдсан “Байнгын бус ажиллагаатай сонгуулийн байгууллагад ажиллах ажилтны мэдээллийн сан бүрдүүлэх, сургалт зохион байгуулах, гэрчилгээ олгох тухай журам”-ын 4.2-т /Сургалтын зардал нь албан томилолтын болон унааны, хичээл заасан багшийн ажлын хөлс, бичиг хэргийн зардлаас бүрдэнэ. Албан томилолт нь Сангийн сайдын тушаалаар баталсан томилолтын зардлын хэмжээтэй байна./ гэж тодорхой заасан боловч онцгой нөхцөл байдал үүссэн үед гарч болзошгүй зардал, саналын хайрцаг хүргэх, санал авах байрны болон санал авах байр бэлтгэх, тохижуулах зардал зэрэг зарим зардлын зүйлд ямар ямар зардал тооцогдохыг журамд тодорхой зааж өгөөгүй байна.

Тиймээс дээрх зардлуудын талаар журамд тодорхой зааж оруулах талаар Сонгуулийн Ерөнхий хороонд уламжилж байна

Бүлэг 2.

Сонгууль зохион байгуулах зардлын гүйцэтгэлийг бодитой тайлагнасан боловч зарцуулалтад хяналт тавиагүй байна.

Сонгууль зохион байгуулах зардлыг нийт 258,619.2 мянган төгрөгөөр төлөвлөснөөс 246,598.3 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй, 12,020.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй ажиллаж, үлдэгдлийг Сонгуулийн Ерөнхий Хороонд төвлөрүүлсэн байна. Буцаан төвлөрүүлсэн дүнг сонгуулийн хороо тус бүрээр харууллаа. /Хүснэгт 2.1/

Хүснэгт 2.1

Сонгуулийн хорооны нэр	Буцаан төвлөрүүлсэн дүн
Дэлгэрхангай	630.6
Дэлгэрцогт	4.5
Дэрэн	0.4
Говь-Угтаал	1.0
Баянжаргалан	290.9
Өндөршил	496.9
Сайнцагаан	9.7
Аймаг	10,586.9
Нийт	12,020.9

Аймгийн сонгуулийн хороо Сонгуулийн Ерөнхий Хорооны 2016 оны 03 дугаар сарын 2-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор батлагдсан ”Сонгуулийн хороодод төсөв

хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам”-ын 4.4⁷-т заасан хугацаанд сонгуулийн зардлын тайланг Сонгуулийн Ерөнхий Хороонд хүргүүлсэн байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль зохион байгуулах үеэр нийт 190 нэр төрлийн 1,598.3 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн боловч 398.0 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэж, 1,400.3 мянган төгрөгийн хөрөнгө бүртгээгүй байв.

Бүртгээгүй хөрөнгүүдийг УСНББОУС 12, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.2-т /Нягтлан бодох бүртгэлд бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг заавал бүртгэнэ./ гэж заасны дагуу сонгуулийн хэсгийн хороод байрлаж байсан байгууллагад бүртгэж авахыг аудитын явцад зөвлөлөө.

Аудитын явцад Сонгуулийн Ерөнхий Хорооноос ирүүлсэн төсөв зарцуулах зөвлөмжийн дагуу сонгуулийн хорооны гишүүдийн хоол, урамшууллын зардлын гүйцэтгэлийг давтан тооцоолоход зөрүү гараагүй. /Хүснэгт № 2.2, 2.3/

Урамшууллын зардлын тооцоо

Хүснэгт 2.2 /мянган төгрөгөөр/

Зардлын зүйл	Тоо	СЕХ-ны аргачлалаар нэг ажилтны	Нийт үнэлгээ
Аймгийн сонгуулийн хорооны гишүүдийн урамшуулал	9	345.6	3,110.4
Сумын сонгуулийн хорооны гишүүдийн урамшуулал	79	230.4	18,201.6
Санал авах байрны ахлах ЗБ-гчийн урамшуулал	52	211.2	10,982.4
Санал авах байрны ЗБ-гчийн урамшуулал	268	192.0	51,456.0
МТ багийн гишүүний урамшуулал	5	345.6	1,728.0
Санал авах байрны даамлын урамшуулал	67	230.4	15,436.8
Нягтлан бодогч бичиг хэргийн ажилтны урамшуулал	2	800.0	1,600.0
Нийт	482		102,515.2
Аймгийн сонгуулийн хорооны нэгтгэсэн тайлангаар			102,513.6

Хоолны зардлын тооцоо

Хүснэгт 2.3 /мянган төгрөгөөр/

Зардлын зүйл	Тоо	СЕХ-ны аргачлалаар нэг ажилтны хоолны зардал	Нийт үнэлгээ
--------------	-----	--	--------------

⁷ /Сум, дүүргийн сонгуулийн хорооны болон салбар комиссын дарга, нарийн бичгийн дарга нар 4.3-т заасан тайланг сонгуулийн санал хураалт дууссан өдрөөс хойш 3 хоногийн дотор гарган аймаг, нийслэлийн сонгуулийн хороо болон төв комисст, аймаг, нийслэлийн сонгуулийн хороо болон төв комиссын дарга, нягтлан бодогч нар энэ журмын 4.3-т заасан тайланг нэгтгэн 4.2-т заасны дагуу нэгдсэн тайланг сонгуулийн санал хураалт дууссан өдрөөс хойш 30 хоногийн дотор гаргаж Сонгуулийн Ерөнхий Хороонд тус тус хүлээлгэж өгнө./

Сонгуулийн байгууллагын ажилтны хоолны зардал	408	50.0	20,400.0
МТ багийн гишүүний хоолны зардал	5	40.0	200.0
Санал авах байрны даамлын хоолны зардал	67	30.0	2,010.0
Нягтлан бодогч бичиг хэргийн ажилтны хоолны зардал	2	50.0	100.0
Нийт	482		22,710.0
Аймгийн сонгуулийн хорооны нэгтгэсэн тайлангаар			22,710.0

Аймгийн сонгуулийн хороо байнгын бус үйл ажиллагаатай байдаг тул сонгууль зохион байгуулах зардлын гүйцэтгэлд хийх аудитыг сонгууль зохион байгуулах явц дунд сонгуулийн хороод татан буугдахаас өмнө хийж дуусгах нь үр дүнтэй байна.

2.2 Аймгийн сонгуулийн хорооноос сонгуулийн зардлын зарцуулалтад хяналт тавиагүй байна.

Сонгуулийн Ерөнхий Хорооны 2016 оны 03 дугаар сарын 2-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор батлагдсан "Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам"-ын 3.4-т /Сонгуулийн Ерөнхий Хороо нь аймаг, нийслэлийн сонгуулийн хороо болон төв комиссын сонгуулийн зардлын зарцуулалтанд, аймаг, нийслэлийн сонгуулийн хороо нь сум, дүүргийн сонгуулийн хорооны, төв комисс нь салбар комиссын сонгуулийн зардлын зарцуулалтанд тус тус хяналт тавина./ гэж заасан боловч аймгийн сонгуулийн хороо сумдын сонгуулийн хороодод хяналт хийгээгүй байна.

Энэ талаар тодруулахад аймгийн сонгуулийн хорооноос сумдад хяналт хийх цаг хугацаа, хүний нөөцийн боломж байхгүй бөгөөд сумдын сонгуулийн хорооны дарга, нарийн бичиг, нягтлан бодогч нарт 2 удаа сургалт зохион байгуулахдаа анхаарах асуудлуудыг танилцуулсан гэсэн тайлбар өгөв.

ДЭЭД ШАТНЫ БАЙГУУЛЛАГАД ХҮРГҮҮЛЭХ
САНАЛ



ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг өгч байна. Үүнд:

- Аймгийн ИТХ-ын сонгуулийг зохион байгуулах хөрөнгийг холбогдох хууль, журмын дагуу зарцуулсан байна.
- Зарим сумдын сонгуулийн хороонд хуваарилсан төсөв сумдын эдийн засаг, статистикийн тоон үзүүлэлттэй уялдахгүй байна.
- Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан боловч нийт гүйцэтгэлийн 0.3 хувьд зөрчил илэрлээ.
- Сонгууль зохион байгуулах зардлын гүйцэтгэлийг бодитой тайлагнасан боловч зарцуулалтад хяналт тавиагүй байна.
- Аймгийн сонгуулийн хорооны сонгууль зохион байгуулах зардлын гүйцэтгэл 95 хувьтай байна.
- Аймгийн сонгуулийн хорооноос сонгуулийн зардлын зарцуулалтад хяналт тавиагүй байна.

ТАЙЛАН БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР

Х.НАРАНЦАЦРАЛ

ШИНЖЭЭЧ

Ч.БЭРХСАЙХАН

ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН САНАЛ ТАЙЛБАР

Төрийн Аудитын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.1-т заасны дагуу аудитын тайлангийн төслийг аймгийн сонгуулийн хороонд танилцуулж, 2016 оны 07 дугаар сарын 29-ний өдөр санал тайлбарыг авахаар хүргүүлэв.

Сонгуулийн Ерөнхий Хорооны 2016 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 261 дүгээр тогтоолоор аймгийн сонгуулийн хороог 2016 оны 07 дугаар сарын 25-ны өдрөөр татан буулгасан тул албан ёсны санал тайлбар өгөх боломжгүй бөгөөд 2016 оны 08 дугаар сарын 01-ны өдөр ирүүлсэн сонгуулийн хорооны дарга, нягтлан бодогч нарын гарын үсэгтэй тайлбарыг тайлангийн хавсралтад орууллаа.

АУДИТЫН ГАЗРЫН ТАЙЛБАР

Төрийн Аудитын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.2-т заасны дагуу дараах тайлбарыг өгч байна. Үүнд:

- Сонгуулийн тухай хуулийн 59.1-д /Энэ хуульд өөрөөр заагаагүй бол орон нутгийн хурлын сонгуульд нэр дэвшигч нь санал хураалт явагдсан өдрөөс хойш 30 хоногт багтаан сонгуулийн зардлын тайлан гаргаж тухайн шатны сонгуулийн байгууллагад хүргүүлэх үүрэгтэй./, 59.3-т /Нэр дэвшигчийн сонгуулийн зардлын данс байршуулсан банкны захирал, эсхүл салбарын эрхлэгч нь уг дансны бүх гүйлгээг нэгтгэсэн тайлан гаргаж, санал хураалт дууссан өдрөөс хойш 45 хоногийн дотор тухайн шатны сонгуулийн байгууллагад хүргүүлнэ./ гэж заасан. Гэтэл аймгийн сонгуулийн хороог 2016 оны 07 дугаар сарын 25-ны өдрөөр буюу хуулинд заасан дээрх үүргүүдийг бүрэн хэрэгжүүлээгүй байхад татан буулгажээ. Иймд энэ асуудлыг Сонгуулийн Ерөнхий Хороонд анхааруулах талаар Үндэсний Аудитын газарт санал хүргүүлж байна.
- Аймгийн сонгуулийн хороо татан буугдсан тул ирүүлсэн тайлбарыг хүлээн авах боломжгүй гэж үзлээ.

ТАЙЛАНГ БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ДУНДГОВЬ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2016 оны 08 сарын 29 өдөр

Дугаар 4/22

Мандалговь

Гүйцэтгэлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.5 дахь заалт, "Гүйцэтгэлийн шалгалтын журам"-ын 23.2, "Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам"-ын 4.2-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. "Монгол Улсын Их Хурлын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн зардлын гүйцэтгэл"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан (ҮАГ-ГАГ/2016/07-ГА), илэрсэн төлбөр, зөрчлийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

Хоёр. Аудитын тайланг Үндэсний Аудитын Газар болон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Сонгуулийн хороонд тус тус хүргүүлсүгэй.

Гурав. Аудитын тайланд дурдагдсан зөрчлүүдийг дахин давтан гаргахгүй байхад анхаарч ажиллахыг шинээр томилогдсон аймгийн сонгуулийн хороонд зөвлөсүгэй.

Дөрөв. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг ахлах аудитор /Х.Наранцацрал/-т үүрэг болгосугай.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ОЮУНЧИМЭГ

ТАЙЛАНГИЙН ХАВСРАЛТУУД

Хавсралт №1

Дундговь аймгийн орон нутгийн сонгуулийн салбар болон хэсгийн хороодод ажилласан ажилчдын судалгаа

№	Сумдын нэр	Хэсгийн хорооны тоо	Дарга	СХ-ны нарийн бичгийн дарга	СХ-ны гишүүд	Ахлах зохион байгуулагч	Зохион байгуулагч	Даамлын багийн гишүүд	Бүгд / Хүний тоо /
1	Өлзийт	3	1	1	3	3	18	4	30
2	Хулд	4	1	1	3	4	24	5	38
3	Луус	3	1	1	3	3	12	4	24
4	Дэлгэрхангай	2	1	1	3	2	12	3	22
5	Сайхан-Овоо	3	1	1	3	3	18	4	30
6	Эрдэнэдалай	7	1	1	5	7	28	8	50
7	Адаацаг	5	1	1	3	5	20	6	36
8	Дэлгэрцогт	1	1	1	3	1	6	2	14
9	Дэрэн	4	1	1	3	4	24	5	38
10	Цагаандэлгэр	1	1	1	3	1	6	2	14
11	Говь-Угтаал	1	1	1	3	1	6	2	14
12	Баянжаргалан	3	1	1	3	3	12	4	24
13	Өндөршил	1	1	1	3	1	6	2	14
14	Гурвансайхан	5	1	1	3	5	30	6	46
15	Сайнцагаан	9	1	1	5	9	46	10	72
16	Аймгийн төв		1	1	7			5	14
	Нийт	52	16	16	56	52	268	72	480

Хавсралт №2

Сонгуулийн тухай хуульд улсын төсвөөс санхүүжих зардлын зүйл	Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журамд заасан аймгийн сонгуулийн хороодод хуваарилах зардлын зүйл	Сонгуулийн Ерөнхий Хорооноос хуваарилсан зардлын зүйл
<p>38.2.1.сонгуулийн байгууллагын үйл ажиллагааны зардал;</p> <p>38.2.2.нэр дэвшигчийн үнэмлэх, сонгуулийн штабын ажилтан, менежер, шадар туслагч, ухуулагч болон сонгуулийн ажиглагчийн үнэмлэх хэвлэх, хүргүүлэх зардал;</p> <p>38.2.4.саналын хуудас хэвлүүлэх, хамгаалах, хүргүүлэх зардал;</p> <p>38.2.5.сонгуулийн дүн, мэдээний маягт, бие даан нэр дэвшигчийн дэмжигч-сонгогчийн гарын үсэг цуглуулах маягт, сонгуулийн байгууллагын албан бичгийн хэвлэмэл хуудас хэвлэх, хүргүүлэх зардал;</p> <p>38.2.6.тамга, тэмдэг, лац, саналын хуудас битүүмжлэн хадгалах уут бэлтгэх зардал;</p> <p>38.2.7.санал авах, тоолох, дүн гаргах ажиллагаанд хэрэглэх техник, тоног төхөөрөмж, тэдгээрийн сэлбэг хэрэгсэл, программ хангамж, худалдан авах, түрээслэх, ашиглах, хадгалах, хамгаалах, засвар үйлчилгээ хийх, тээвэрлэх болон даатгал, тусгай тэмдэглэл хийх хэрэгсэл, тэдгээрийг худалдан авах, түрээслэх, ашиглах, хамгаалах, хадгалах, засвар үйлчилгээ хийх, хэвлэх, үйлдвэрлэх, тээвэрлэх, хүргэх, татан авах зардал;</p>	<p>2.2.3. сонгуулийн автоматжуулсан систем ашиглахтай холбоотой гарах зардал;</p> <p>2.2.2. тогтоол, протокол, албан бичгийн хэвлэмэл хуудас, маягт хэвлүүлэх зардал;</p> <p>38.2.5</p> <p>2.2.1. сонгуулийн бичиг баримт болон техник хэрэгслийг сум, дүүргийн сонгуулийн хороо, санал авах байранд хүргэх, буцаан татах, тээвэрлэх зардал; 38.2.7</p>	<p>Саналын хуудас хүргэх ICP машиныг хүлээн авах, хүлээлгэн өгөх</p> <p>МТБ-ийн мэдээ дамжуулах зардал</p> <p>Үнэмлэх хэвлүүлэх зардал</p> <p>Саналын хуудас устгах зардал</p> <p>Маягт хэвлэх зардал</p>

<p>38.2.8.санал хураалтын дүнгийн мэдээ дамжуулах зардал;</p> <p>38.2.9.саналын хайрцаг хийх, хүргэх, санал авах байрын болон санал авах байр бэлтгэх, тохижуулах зардал;</p> <p>38.2.10.сонгуулийн хууль тогтоомж болон сонгууль зохион байгуулахтай холбогдсон эрх зүйн бусад акт, гарын авлага, сургалт, сурталчилгааны материал боловсруулах, хэвлэх, хүргэх зардал;</p> <p>38.2.11.сонгуулийн байгууллагын ажилтан, мэдээллийн технологийн багийн гишүүн, даамал, нөөц даамлын сонгууль зохион байгуулахтай холбогдсон сургалтын зардал;</p> <p>38.2.12.сонгуулийн хууль тогтоомжийг сурталчлах болон сонгууль зохион байгуулах, түүний бэлтгэл ажлын явц, хугацааны талаар сонгогчдыг мэдээллээр хангах арга хэмжээний зардал;</p> <p>38.2.13.сонгуульд нэр дэвшүүлсэн нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн санхүүжилт, зарцуулалтыг хянан шалгахад гарах зардал;</p> <p>38.2.14.нэмэлт болон дахин санал хураах, ээлжит, ээлжит бус, нөхөн болон дахин сонгууль явуулах зардал;</p> <p>38.2.15.сонгуулийн байгууллагын ажилтан, мэдээллийн технологийн багийн болон ажлын хэсгийн гишүүн, даамал, нөөц даамлын тухайн</p>	<p>2.2.4. дүн мэдээ дамжуулах зардал; 38.2.8</p> <p>2.2.5. санал авах байр бэлтгэх, тохижуулах зардал; 38.2.9</p> <p>2.2.6. сонгуулийн байгууллагын ажилтан, мэдээллийн технологийн багийн гишүүн, даамал, нөөц даамлын сонгууль зохион байгуулахтай холбогдсон сургалтын зардал; 38.2.11</p> <p>2.2.7. сонгуулийн байгууллагын ажилтан болон мэдээллийн технологийн багийн гишүүн, даамал, нөөц даамлын тухайн</p>	<p>Санал авах байр бэлтгэх зардал</p> <p>Сурталчилгааны зардал</p> <p>Сургалтын зардал</p> <p>Сонгуулийн байгууллагын ажилтны урамшуулал, хоол МТБ, даамлын урамшуулал, хоол Бичиг хэргийн</p>
---	---	--

<p>сонгуулийн байгууллагад ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал;</p> <p>38.2.16.сонгуулийн байгууллагын бичиг хэрэг, шуудан, холбоо, унаа, албан томилолтын зардал;</p> <p>38.2.18.онцгой нөхцөл байдал үүссэн үед гарч болзошгүй зардал;</p> <p>38.2.19.сонгуулийг зохион байгуулахтай холбогдсон бусад зардал.</p>	<p>сонгуулийн байгууллагад ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал; 38.2.15</p> <p>2.2.8. бичиг хэргийн зардал; 38.2.16 2.2.9. шуудан, холбооны зардал; 38.2.16 2.2.10. унааны зардал; 38.2.16 2.2.11. албан томилолтын зардал; 38.2.16</p>	<p>болон нягтлан бодогч нарын урамшуулал</p> <p>Бичиг хэргийн зардал Шуудан холбоо</p> <p>Томилолтын зардал САС-ийн зардал /эрчим хүчний эх үүсгэвэр/</p> <p>Унааны зардал</p> <p>Болзошгүй зардал</p>
--	--	--



Сонгуулийн тухай хуульд улсын төсвөөс санхүүжихээр заасан боловч журамд аймгийн сонгуулийн хороодод хуваарилах зардалд ороогүй зардлууд.



Сонгуулийн Ерөнхий Хорооноос аймгийн сонгуулийн хороонд хуваарилсан зардлаас журамд заагдаагүй зардлууд.

ДУНДГОВЬ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

2016.08.01

Мандалговь

Тайлбар хүргүүлэх тухай

Монгол Улсын Их хурлын болон аймгийн ИТХ-ын 2016 оны ээлжит сонгуулийн зардлын зарцуулалтад гүйцэтгэлийн аудит хийсэн тайлангийн төсөлтэй танилцлаа.

Байнгын бус ажиллагаатай аймгийн Сонгуулийн байгууллага нь Сонгуулийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, журам зааврыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилласан.

Гүйцэтгэлийн аудитыг зохих хууль журмын дагуу үр дүнтэй сайн зохион байгуулсан гэж үзэж, аудитын дүгнэлтийг хүлээн зөвшөөрч байна. Гэвч зарим дүгнэлттэй санал нийлэхгүй байгаа тул дараах тайлбарыг хүргүүлж байна. Үүнд:

1. Сонгуулийн Ерөнхий хорооноос зардлыг хуваарилахдаа санхүүжилтийг санал авах өдрөөс хэдхэн хоногийн өмнө маш богино хугацаанд 2-3 хуваан тухай бүр шилжүүлж байсан. Мөн сүмдын Сонгуулийн хороодын ня-бо нарыг 2 удаа сургалтанд хамруулж, үтсаар болон албан тоотоор удаа дараа зөвлөмж чиглэл өгч ажилласан.

Аймгийн Сонгуулийн хорооноос нарийвлан төлөвлөгдсөн графикт бусад ажлуудтай давхардаж, хүн хүч, цаг хугацааны боломж гараагүй тул тэдний үйл ажиллагаанд явцын хяналт тавих боломжгүй байсан бөгөөд мэргэжлийн нягтлан бодогч нарыг сургалтанд хамруулсан тул хяналт тавих шаардлагагүй гэж үзсэн болно. Иймд “Аймгийн Сонгуулийн хорооноос сонгуулийн

зардлын зарцуулалтад хяналт тавиагүй” гэсэн аудитын дүгнэлтийг дахин нягталж үзнэ үү.

- Сүмдын Сонгуулийн хороонд төсвийг хуваарилахдаа тухайн сүмдын санал авах байрны тоо, тэнд ажиллах төрийн албан хаагчид, сонгогчдын тоог харгалзан үзсэн болно. Тухайлбал Гурвансайхан, Дэрэн, Луус, Адаацаг сүмдын санал авах байрны тоо бусад сүмдаас илүү бөгөөд Адаацаг сум л гэхэд Өндөршил сумаас 3 дахин олон сонгогчтой байсан.

Сумын Сонгуулийн хороодоос төсвийн хуваарьтай холбоотой ямар нэг санал хүсэлт ирүүлээгүй болно.

ТАЙЛБАР ХИЙСЭН: АЙМГИЙН СОНГУУЛИЙН ХОРООНЫ

ДАРГА
НЯ-БО



Д.ДУЛМАА
Ц.СУГИР